

## 2025 ОНД “ ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН ”-ИЙН

### ХӨРӨНГӨӨР ХИЙГДСЭН АЖЛУУД

- Сумын ерөнхий хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг 170.0 сая төгрөгөөр “Эрхэт конштракшн” ХХК хийж 90 хувийн гүйцэтгэлтэй. Магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулж сумын ИТХ-аар хэлэлцүүлэх шатанд явагдаж байна.
- Сумыг засмал замтай холбох 20км авто замын зураг төсөв боловсруулах ажлыг 148.0 сая төгрөгөөр "Жи Ар Си" ХХК гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.
- Залуучууд хөгжлийн төв, спорт заалны сантехникийн засварын ажлыг 11.5 сая төгрөгөөр иргэн Б.Энэдарамаар гүйцэтгүүлж ажлыг хүлээж авсан.
- Сумын төв доторх нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, ногоон байгууламжийн арчилгаа, хатуу хучилттай авто замын арчилгаа болон хог хаягдлыг цуглуулах зайлуулах ажил хийгдсэнээр сумын төвийн өнгө үзэмж сайжирч иргэд цэвэр аюулгүй орчинд амьдарч ажиллах орчин бүрдсэн.
- ЕБС болон ЭМТ-ийн гал тогооны тоног төхөөрөмж шинэчлэх ажлыг 15.0 сая төгрөгөөр "Чиглэл " ХХК гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.
- Сумын төвд гэрэлтүүлэг хийх ажлыг 19.8 сая төгрөгөөр "Оджи Од" ХХК Сумын төв болон Чигчий хороололд 2 ширхэг 8-н талт цамхаг гэрэл ажиллагаанд оруулав.
- Мал угаалгын тоног төхөөрөмжөөр хангах зорилгоор ариутгалын 2 ширхэг дук машин худалдан авах ажлыг 78.0 сая төгрөгөөр “Аргабилэг Тогтох” ХХК гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.
- Гамшгаас хамгаалах зорилгоор сумын аюулгүйн нөөцөд малын тэжээлийн өвс 2330 боодол, хивэг 800 шуудайг нийт 54.9 сая төгрөгөөр “Боригдой Эл Эс Ар” ХХК нийлүүлэлт хийж хүлээж авсан.
- Мал эмнэлгийн лабораторийн тоног төхөөрөмжийн тестийг 1.95 сая төгрөгөөр “Атар-Ирээдүй” ХХК нийлүүлж хүлээн авсан.